



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 476

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны “Эрчим хүчний үр ашиг 3+” татан буугдсан төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 64,101,505.00 (жаран дөрвөн сая нэг зуун нэгэн мянга таван зуун таван) төгрөгийн балансын үнэ, 36,858,365.40 (гучин зургаан сая найман зуун тавин найман мянга гурван зуун жаран таван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Эрчим хүчний яамны “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл” хэрэгжүүлэх нэгжид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл” хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Г.Мөнхцоодол нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны ЧАУЧЭР САРЫН 19-ны өдрийн  
476 дугаар тоотоолын хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ "ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГ 3+" ТАТАН БУУГДСАН ТӨСЛӨӨС "10 АЙМГИЙН ТӨВИНИН БУЛААНЫ СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ" ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/Д	Автомашины марк, улсын дугаар, арап	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Моторын эзэлхүүн	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ландкруйзер 200, 04-92 УНА, JTBNI09J405069859	2013/2013	B.4000	64,101,505.00	36,858,365.40	27,243,139.60

Нийт дүн  
(жаран дөрвөн сая нэг зуун нэгэн мянга таван зуун таван төгрөг)

(гучин зургаан сая найман зуун тавин найман мянга таван зуун жаран таван төгрөг дөчин мөнгө)

(хорин долоон сая хоёр зуун дөчин гурван мянга нэг зуун гучин есөн төгрөг жаран мөнгө)